

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ашигладаг химийн бодисууд.....	9
Хүснэгт 2. Бохирдуулагч бодисын хэмжээ.....	18
Хүснэгт 3. Дуу, шуугианы төвшин, эрүүл ахуйн шаардлага.....	18
Хүснэгт 4. Оноот үнэлгээний нэгдсэн дүн.....	24
Хүснэгт 5. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөллийн оноот үнэлгээ.....	24
Хүснэгт 6. Гадаргын болон газрын доорх усны чанарт үзүүлж болзошгүй нөлөөллийн оноот үнэлгээ.....	24
Хүснэгт 7. Хөрсөнд үзүүлж болзошгүй нөлөөллийн оноот үнэлгээ.....	24
Хүснэгт 8. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн оноот үнэлгээ.....	25
Хүснэгт 9. Нийгэм, эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ.....	26
Хүснэгт 10. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.....	29
Хүснэгт 11. 2025 оны Ногоон байгууламжийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 12. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө.....	31
Хүснэгт 13. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө.....	32
Хүснэгт 14. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	33
Хүснэгт 15. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	33

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршлын зураг.....	5
Зураг 2. Хэвлэх үйлдвэрийн гадаад орчны зураг.....	6
Зураг 3. Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, дотоод орчны фото зураг.....	7
Зураг 4. Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, дотоод орчны фото зураг.....	8
Зураг 5. Хэвлэх үйлдвэрлэлийн технологийн схем.....	9
Зураг 6. Химийн бодисын агуулах.....	11
Зураг 7. Улаанбаатар Принт ХХК -ийн хэвлэх үйлдвэрийн план зураг.....	12
Зураг 8. Хэвлэх үйлдвэрийн доторх хог хаягдал ангилан цуглуулах цэг, савууд.....	12
Зураг 9. Хэвлэх үйлдвэрийн цаасан болон гялгар хог хаягдал багцлах машин.....	13
Зураг 10. Хэвлэх үйлдвэрийн цаасан болон гялгар хог хаягдал багцалсан байдал.....	13
Зураг 11. Төслийн талбайн дотоод орчны тэмдэг, тэмдэглэгээ мэдээллийн самбарын фото зураг.....	14
Зураг 12. Хэвлэх үйлдвэрийн түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүний агуулах.....	15
Зураг 13. Төслийн талбайн өндөршлийн зураг.....	16
Зураг 14. Агаарын температурын сүүлийн 5 жилийн байдал.....	17
Зураг 15. Төслийн талбай орчмын гадаргын усан сүлжээ.....	19
Зураг 16. Газрын доорх усны нөөцийн ангилал.....	19
Зураг 17. Төслийн талбайд гархсан хөрс.....	20
Зураг 18. Төслийн талбайн ургамалжилт.....	21
Зураг 19. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужууд.....	22
Зураг 20. Улсын тусгай хамгаалалттай газар.....	22
Зураг 21. Төсвийн орлого, зарлага, 2013-2021 онд. сая төг.....	23

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Хэвлэх үйлдвэрийн танилцуулга

Тус байгууллага 1997 оны 03 сарын 01-нд нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр “Монгол дэвтэр” нэртэйгээр байгуулагдсан хэвлэлийн салбарын ууган компаниудын нэг юм. Анх Таван богд менежмент нэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд 2021 оны 02-р сарын 01-ны өдрөөс эхлэн Улаанбаатар Принт ХХК, 2025 оны 5-р сард “Ю БИ ПИ” ХХК нэртэйгээр одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. 2026 оны 01 сарын байдлаар 159 хүний бүрэлдэхүүнтэй 3 ээлжээр 24 цаг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар тус компани нь Сурагчийн дэвтэр, Мэдлэгтэй дэвтэр, өнгөт хэвлэл, посын цаас зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд Тайланд улсын “Double A” нэрийн бичгийн цаас, бичиг хэрэгслийн цор ганц албан ёсны борлуулагчаар 2006 оноос өдийг хүртэл ажиллаж байна. Үйлдвэрлэлийнхээ тасралтгүй үйл ажиллагааг хангахын тул Хэвлэлийн зориулалтай нийт 37 тоног төхөөрөмж, 16 тээврийн хэрэгслийг тус тус ашиглаж байна. Дэд бүтцийн хувьд төвийн нэгдсэн системд холбогдсон ус болон цахилгаан ашигладаг, үйлдвэрлэлийн бүсэд байршилтай. Таванбогд группийн охин компани бөгөөд группийн хэмжээнд нийт 250 орчим автомашины зогсоолтой, бүрэн асфальт хучмал зам талбайтай ба нийт барилгын талбайн урд болон хойд хэсэгт ногоон байгууламж зүлэгжүүлэлттэй. Цэвэр бохир усны төвийн системд холбогдсон. Барилгын хойд хэсэгт нэгдсэн хог хаягдал түр цуглуулах цэгтэй ба дахивар /цаас/, дахивар /гялгар уут, хуванцар сав/ болон энгийн хог хаягдал гэсэн 3 төрлөөр ангилж цуглуулдаг. Хог хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагааг Эко Орчин ХХК болон Цэцүүх Трсйд ХХК-тай гэрээлэн гүйцэтгүүлдэг.

Төслийн нэр	: Хэвлэх үйлдвэр
Төслийн байршил	: Хан-Уул дүүргийн 3-р хороо
Төсөл хэрэгжүүлэгч	: Ю БИ ПИ ХХК
Улсын бүртгэлийн дугаар	: 9011509045
Регистрийн дугаар	: 5887712
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө, Таван богд группийн Салбар оффис

1.2. Төслийн үйл ажиллагаа, цар хүрээ

Ю БИ ПИ ХХК-ийн хэвлэх үйлдвэр нь тоног төхөөрөмжөө байнга шинэчлэн сайжруулан ажилласаар ирсэн байна. Тухайлбал:


- 2002 онд SM52-52 хэвлэх машины суурилуулснаар офсет, өнгөт хэвлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж ирсэн.
- 2008 онд хэвлэх үйлдвэрийг бүрэн шинэчлэн дэлхийд тэргүүлж буй хэвлэхийн өмнөх, хэвлэхийн дараах тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийснээр чанар, бүтээмж шаардсан, захиалгын тоо өндөртэй, өндөр зэрэглэлийн хэвлэлийн ажлыг хийдэг болсон.
- 2011 оны 11-р сард дахин шинэ хэвлэлийн машин суурилуулснаар хүчин чадал 2 дахин нэмэгдсэн.
- 2021 онд цаас цаасан уут үйлдвэрлэлийн бүрэн автомат машин нэмэлтээр байршуулсан.
- 2025 онд цахилгаан зарцуулалт багатай инвертор бүхий болт машин, холионы машин, цавууны машин зэрэг тоног төхөөрөмжүүд худалдан авч сайжруулалт хийсэн
- Монголд анх удаа өнгөний удирдлагын программыг нэвтрүүлсэн байна

Зорилго: Өнгөт хэвлэлийн үйлдвэр нь орчин үеийн технологиор ном, сэтгүүл, плакат зэрэг бүх төрлийн хэвлэлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргахад оршино.

1.3. Ажиллах хүч

“Ю БИ ПИ” ХХК-ийн Улаанбаатар Принт хэвлэлийн үйлдвэр нь 2026 оны байдлаар 159 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 3 ээлжээр 24 цаг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. Үйлдвэрийн үйлдвэрлэх хэсэгт нийт 89 ажилтан байх ба бусад ажилчид оффис болон борлуулах хэсэгт ажиллана.

Хэвлэх үйлдвэрийн байршил: Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 3-р хороо 19 хороолол Таван богд холдингс ХХК-ийн салбар оффист 3,808 м2 талбайг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 1. Төслийн байршилын зураг





Зураг 2. Хэвлэх үйлдвэрийн гадаад орчны зураг

1.4. Хэвлэх үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж

Ю БИ ПИ ХХК-ийн хэвлэх үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийг доорх хүснэгтэд харуулав. Үйлдвэрийн үйл ажиллагаанд нийт 32 машин техник, тоног төхөөрөмжийг ашиглаж байна.

№	Машины нэрс	Ашиглалта нд орсон огноо	Тоног төхөөрөмжийн нажилт (жил)	Насжилт
1	1 3 н тал огтлолоо	2024	0	0-5 жилийн нажилттай 6 тоног төхөөрөмж
	2 Шинэ пакет машин SMW50	2024	0	
	3 pressing machine - Прессний машин	2023	1	
	4 Уутны машин	2021	3	
	5 Уутны зүсэгч	2021	3	
	6 SL-120H - Хавтан угаах машин	2020	4	
2	7 RY850-4B Flexo Printing machine - Флексо хэвлэл	2019	5	5-10 жилийн нажилттай 13 тоног төхөөрөмж
	8 Automatic shrink packing machine BTA-450 - Пакетний машин	2019	5	
	9 YJ-500 hydraulic book back pressing machine	2019	5	
	10 HGJ-100 Slitting paper machine - Посын цаас зүсэгч машин	2019	5	
	11 FZ-470 Seam folding machine- Шулуун оёо	2019	5	
	12 Bolt RB-104 - Дрэгэрийн бүрэн автомат машин	2025	1	
	13 Knife Grinder HM2016-Z machine - Хууга ирлэгч	2018	6	
	14 NCD-9E - Огтлоо шинэ	2017	7	
	15 Protopic Auto S540 - Шинэ бүрэлтний машин	2017	7	
	16 Coner cutting - Булан дугуйлагч	2017	7	
	17 KALSi machinery Book Back Pressing Machine - Эгзгэхэг нуруу дөрвөлжлөгч	2016	8	
	18 SuperBinder 50B - Цавууны машин	2016	8	
	19 STAMPING AND DIE CUTTING MACHINE TYMK-750 - Эсгүүр огтлоо (Тигель)	2015	9	
	20 SXE-460 - Bosid machinery - Оёоны машин хуучин	2013	11	

3	21	Komori -II Lithrone S429e	2011	13	жилийн насжилттай 13 тоног төхөөрөмж
	22	THREE HOLES DRILLING MACHINE 3ZK220 - Нүхтэх машин	2011	13	
	23	MULTI-FUNCTIONAL PUNCHING MACHINE СК-600А - Цоологч машин	2011	13	
	24	WIRE PRESSING MACHINE DYQ-600- Стериал дарагч машин	2011	13	
	25	YDFM -720 - Бүрэлтний машин	2010	14	
	26	Komori -I Lithrone S429	2008	16	
	27	Screen Plate 8600rs - Хавтан шарах машин	2008	16	
	28	Muller Marthini - Агрегат	2008	16	
	29	NCD-7 - Огтлоо хуучин	2008	16	
	30	Shoei - SPK74 - Нуглаа шинэ	2008	16	
	31	Shoei - SPK - Нуглаа хуучин	2008	16	
	32	Horizon VAC 100 - Холионы машин	2008	16	



Зураг 3. Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, дотоод орчны фото зураг



Зураг 4. Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, дотоод орчны фото зураг

1.5. Хэвлэх үйлдвэрийн технологи

Ю БИ ПИ ХХК-ийн хэвлэх үйлдвэр нь байгаль орчинд хор хөнөөлгүй, хаягдалгүй технологи ашигладаг.



Зураг 5. Хэвлэх үйлдвэрлэлийн технологийн схем

1.6. Хэвлэх үйлдвэрийн түүхий эд, туслах материал, эрсийн бүтээгдэхүүн

Тус хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх химийн хортой 10 нэр төрлийн бодисыг БНХАУ, Япон, БНСАУ-аас тус тус импортлон оруулж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана. Ю БИ ПИ ХХК-ийн хэвлэх үйлдвэрийн импортлон авчирч ашигладаг химийн бодисын хэмжээ нь харилцагч үйлдвэрүүдийн захиалгаас голлон хамаардаг.

Хүснэгт 1. Ашигладаг химийн бодисууд

№	Монгол нэр	ОУ-ын нэр	CAS №	Зориулалт	Хэрэглээ
1	Машин угаах шпингэн	Roller wash up solvent	85-68-7 8052-41-3 7732-18-5	Хавтанд нөлөөлөхгүй, бланкет, булыг товгор болгохгүй. Дээд зэргийн цэвэрлэх чадвартай, зэврэлтийн эерэг, руллон болон хуудсаар хэвлэдэг.	Автомат болон гар ажиллагаагаар ажилладаг машиныг угаана. Үүгээр хавтан түрхцийг арилгахдаа дангаар эсвэл 25%-н устай хольж хэрэглэж болно.
2	Хавтан цэвэрлэгч	Plate cleaner	7732-18-5	Бүдгийг арилгаж үлдэгдлийг цэвэрлэх, хэвтэгдэх хэсгийг сайн гаргах	Хэрэглэхээс өмнө сайтар сэгсэрч superdot хавтан угаагчийн порлонд түрхэж шууд арчиж цэвэрлэх. Нойтон порлоноор үлдэгдлийг арчиана.
3	Бул угаагч	Matering roller cleaner	1330-20-7 68425-35-4 67-63-0 64742-95-6	Бул гэмтээдэггүй бүх төрлийн резинд тохиромжтой, хадгалах горим шаардагдахгүй.	Superdot MRC-аар булыг порлонд эсвэл нойтон даавуугаар цэвэр болтол нь арчиж цэвэрлэх. Дараа нь булыг хатгал нь цэвэр даавуугаар арчих металл бул цэвэрлэхэд хэрэглэх болно.
4	Хөргөгч цэвэрлэгч	Fount clean	7732-18-5 34590-94-8 1310-73-2 6834-92-0	Усанд байх бактерийн үржих чадварыг багасгадаг. Будаг уусгах, усны тогоо, шахуурга, болон нян тараагч зэргийг хүчтэй ариутгагч	Арилгахад хэцүү зүйлд ихээр бохирдсон усны уусмалыг солих үед Fount clean 1:3 үе гэсэн харьцаатайгаар шингэлэх, 30-60 минут зайлж ариутгасны дараа 2 удаа усаар цэвэрлэх

				агуулсан. Усанд байх бактери болон моогонцрийн устгах спектер агуулагдсан. Норгогчийг цэвэрлэхээр зориулагдсан. Зааврын дагуу хэрэглэвэл хэвлэлийн чанарыг удаан дарна.	
5	Кальци арилгагч	Calcium remover	7647-01-0 7664-38-2	Кальцийн үр нөлөөг багасгаж бланкет, булны чанарыг барьж, хэвлэлийн өндөр бүтээмжтэй чанартай байдлыг нэмэгдүүлдэг. Ондор чанартай энэхүү бүтээгдэхүүн нь эдийн засагт хэмигэлтэй. Түргэн хугацаанд үр дүнгээ огч хэвлэлийн цагийг багасгана.	Кальци арилгахдаа 1:1 хэмжээтэй устай шингэлж будагны голд түрхэнэ. Дорхаяж 3 минут байлгана. Цэвэрхэн болтол нь усаар зайгж цэвэрлэх 30% устай хольсон усаар зайлах. Кальци илүү ихээр байгаа тохиолдолд кальци арилгагчийг их хэмжээгээр хольж шингэлэх хэрэглэх.
6	Булны Хэрэглээ ургаагаг	Deglazer	8052-41-3 64742-89-8 75-09-20	Будаг хамгаалах цавуу арилгах, бул болон бланкетны хэрэглээг удаан болгодог. Будаг дамжих гадаргууг цэвэр байлгана.	W112-оор пойтон будгийг угааж цэвэрлэхэд бага хэмжээтэй Superdot deglazer шингэнээр булыг 3-5 минут норгосны дараа W112-р угааж авах
7	Ус зөөлрүүлэгч	FS fount soft	68-04-2 7732-18-5	Спирт багассан, Зөөлрүүлэх хүчтэй шингэн, хоосордоггүй, будаг болон спиртийн хэрэглээг багасгасан.	Арилгах спиртийн хэмжээгээ шаарцаалж 2%- 5% нэмнэ. Хольсон рН харьцаа 4,5-5,5% байна. FS12- ыг хэрэглэхийн өмнө усны савыг бүхэлд нь цэвэрлэсэн байвал зохино.
8	Будагны гол тослох, тосоол	Roller lube	64742-47-8	гель хэлбэртэй хэвлэлийн гол тослох тосоол. Будагны гол будаггүй буюу лакгүй явах үед тосолж түрхэнэ.	Будаг түрхэхдээ тосыг арчиж цэвэрлэх шаардлагагүй. будгийг үхжсэн тосны дэглүүр түрхэж хэрэглэнэ.
9	Гүн цэвэрлэгч	Clean paste	8009-03-8 7646-85-7 107-21-1 12125-02-9 7732-18-5	Бул болон бланкетийг гүн цэвэрлэх	Пойтон будгийг арилга. Гүн цэвэрлэгчээ багахан авч буланд түрхэнэ. 5-10 минут байлгасны дараа W112-оор угаах шингэнээр булыг угааж зайлах. Бланкетны бүх гадаргууг гүн цэвэрлэгчээр арчиж шингэнэ. Дараа нь бланкетыг хэвтэл эхлэхээс өмнө superdot-н угаагчаар угаах. Байрдуулсан бланкетын чанараа алдахгүй удаан хадгалахын тулд гүн цэвэрлэгчийн бланкетанд түрхэж бүхэл шонго эсвэл 7 хоног хадгалж болно. Хэвтэл эхлэхээс өмнө угааж зайлах хэрэглэй.
10	Хавтан боловруулагч	Developer IP-T9		Хөшгөнцагаан хавтан дээр буусал дүрсийг тодруулж, угаах	Хавтан угаагч SPS-95 машины банкинд 60 литр хийж, сорох хоолойд 20 литрийг холбож, цэвэрлэх байдлаар ашиглана. 14 хоног 1 удаа банкинд дахь тодруулагчийг солино. Сорох хоолойд холбосон тодруулагчийг дуусах бүр шингээр цэвэрлэнэ. Шарсан хавтаныг банкинд оруулж автоматаар угаана.

11	Тодруулагч	LHD2WA	126-86-3 14960-06-6 22042-96-2 69013-19-0 1310-58-3 50-70-4 7732-18-5	Хөнгөнцагаан хавтан дээр буусан дүрсийг тодруулж, угаах	Хавтан угаагч SPS-95 машины банканд 60 литр хийж хэрэглэнэ. 14 хоногт 1 удаа банканд дахь тодруулагчийг солино. Шарсан хавтанг банканд оруулж автоматаар угаана
11	Тодруулагч	LHD2RWA	126-86-3 14960-06-6 22042-96-2 1310-58-3 50-70-4 7732-18-5	Хөнгөнцагаан хавтан дээр буусан дүрсийг тодруулах	Хавтан угаагч SPS-95 машины сорох хоолойд 20 литрийг холбож, цэнэглэх байдлаар ашиглана. Холбосон тодруулагчийг дуусах бүр шинээр цэнэглэнэ.




Зураг 6. Химийн бодисын агуулах

1.7. Дэд бүтэн

Ю БИ ПИ ХХК нь “Таван богд” группийн төв агуулахын байранд буюу төвийн халуун болон усны шугам сүлжээнд холбогдсон бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байгууламжид үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрийн байранд нийт 15 төрлийн агуулах болон бусад зориулалтаар ашиглагдах өрөөнүүд байна. Үүнд: Цахилгаан дэд станцын өрөө, түүхий эд материалын агуулах, Double A, хэвлэлийн цаасны агуулах, амралтын өрөө, дэвтэрлэгээний хэсэг, дуусаагүй үйлдвэрлэлийн агуулах, хэвлэлийн дараах хэсэг, өнгөт хэвлэл-2 ширхэг, прессийн өрөө, агуулах, дэвтрийн үйлдвэрлэлийн өрөө, шингэн бодисын агуулах, хувцас солих өрөө зэрэг байна.

Зураг 7. Улаанбаатар Принт ХХК-ийн хэвлэх үйлдвэрийн план зураг


Усан хангамж: Хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаанд байгалийн баялгаас зөвхөн усыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг болно. Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд өдөрт дунджаар 30-40 литр ус үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг байна. Усны хэрэглээг хотын цэвэр усны шугам



сүлжээнээс авч хэрэглэдэг.

Цахилгаан хангамж: Тус хэвлэлийн үйлдвэр нь эрчим хүчийг ахуйн болон хэвлэлийн төхөөрөмжийн хэрэгцээнд ашигладаг. Төхөөрөмжүүдийн хувийн цахилгаан зарцуулалтын хэмжээ бага үзүүлэлттэй ба үйлчилгээний ачааллаас хамаарч сар бүрийн цахилгааны хэрэглээ ялгавартай гардаг ба үйлдвэрийн байрны түрээсний гэрээний дагуу түрээслэгчид төлдөг.

Хог хаягдал: Тус үйлдвэрээс хатуу хог хаягдал болох материалын сав баглаа боодол, картонан хайрцаг болон хэвлэлийн үйл ажиллагаанаас гарсан цаасны үлдэгдэл зэрэг хог хаягдал их хэмжээгээр гарна.



Зураг 8. Хэвлэх үйлдвэрийн доторх хог хаягдал ангилан цуглуулах цэг, савууд

Үйлдвэрээс ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал бага хэмжээгээр гарна. Үйлдвэрлэлийн хог хаягдал нь будаг, цэвэрлэгээ, тосолгооны шингэн зэрэг түүхий эд материалын сав баглаа боодол байна. Тухайлбал хавтан угаах бодисын савлагаа нь 20 литрийн хэмжээтэй цаасан картонан хайрцаг түүний доторх зузаан гялгар уут, будаг, цэвэрлэх шингэний төмөр лааз, канистр, хуванцар

Зураг 9. Хэвлэх үйлдвэрийн цаасан болон гялгар хог хаягдал багцлах машин



Зураг 10. Хэвлэх үйлдвэрийн цаасан болон гялгар хог хаягдал багцалсан байдал





Зураг 11. Төслийн талбайн дотоод орчны тэмдэг, тэмдэгтгээ мэдээллийн самбарын фото зураг




Зураг 12. Хэвлэх үйлдвэрийн түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүний агуулах

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Физик газарзүйн нөхцөл

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг нь Дархан цаазат Богд Хан Уулын баруун хойд талд Туул голын хөндийд байрлана. Туул голын хөндий нь зүүнээс баруун тийш 30 орчим км сунасан, өргөн нь 4-5 км, далайн түвшнээс дээш 1250-1300м өргөгдсөн бөгөөд урд талаараа Баянзүрх уул (1843.3м), хойд талаараа Чингэлтэй түүний салбар уулсаар хүрээлэгдэнэ. Туул голын сав газрын 5.4 хувийг уулын тайга, 11.8 хувийг ойт хээр, 82.8 хувийг хээрийн бүс эзлэх ба 584.2 мянган га газрыг хамарсан Хан Хэнтий (1227074га), Богд Хан Уулын дархан цаазат газар (41651 га), Горхи Тэрэлж(293168 га), Хустайн нурууны (50620 га) байгалийн цогцолбор газар, Молцог элс(491.1га), Батхан уул (21850 га), Хөгнө хан уулын (836123га) байгалийн нөөц газрууд оршино.



Зураг 13. Төслийн талбайн өндөршилтийн зураг

2.2. Геологийн тогтоц, геоморфологи

Тус төсөл нь Хан уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж байна. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь Кембр, Девон, Карбонифероузын элсэн чулуу болон шаварлаг хурдсаас тогтох ба Туул голын ай сав газрын аллювийн тэгш газарт байрладаг. Өнгөн хөрс нь нарийн ширхэгтэй бөгөөд салхи, бороонд хялбар элэгддэг. Туул голын ай савын геологийн бүтэц нь Юрийн болон Триассикийн үеийн боржин болон тунамал чулуулгаас тогтсон.

Гуравдагчийн (Неосене, Палеосене) шаварлаг тунамал хурдас нь дунджаар 80м зузаантай. Туул голын сав газар нь ерөнхийдөө уулархаг, уул нурууд, нарийн гуу жалга болон гол горхиор хүрээлэгдсэн.


2.3. Уур амьсгал

Хотын уур амьсгал бүрэлдэн тогтоход орчны газарзүйн онцлогоос гадна хотжилтын нөлөө илэрдэг учир “хотын бичил уур амьсгал” хэмээх бие даасан судалгааны зүйл гарч ирдэг.

Тус районд цаг уурын ажиглалтын цэг байхгүй учир төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн уур амьсгалын ерөнхий нөхцөлийг Туул голын хөндийд орших Буюнт ухаа цаг уурын өртөөний олон жилийн ажиглалтын мэдээнд тулгуурлан бичив. Туул голын сав газар далайн түвшнээс харьцангуй өндөр өргөгдсөн, далай тэнгисээс алслагдсан, эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн тул бичил масштабын хувьд өөрийн онцлогтой бөгөөд түүний уур амьсгалын онцлог шинжийг авч үзвэл өдөр, шөнийн агаарын температурын ялгаа их, хүйтний улирал харьцангуй урт үргэлжилдэг бөгөөд тогтуун, харин зун богино, хур тунадасны ихэнх хувь дулааны улиралд орох бөгөөд голдуу агаарын тогворгүйжлээс үүдэх конвекциос гаралтай байдаг.

Агаарын температур:

Улаанбаатар нь агаарын температурын хойд бүсэд хамаардаг бөгөөд өвөл нь урт, зун нь богино байдаг учир цаг агаарын эрс тэс уур амьсгалтай. Улаанбаатар хот нь хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог бөгөөд жилийн дундаж температур ойролцоогоор цельсийн -30°C -аас $+25^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлздэг.



Зураг 14. Агаарын температурын сүүлийн 5 жилийн байдал

Хур тунадасны горим

Нэг хоногт ихээхэн хур тунадас орох нь өвөл зуд болох, зун хөрсний угаагдлыг ихэсгэн үржил шимийг муутгахаас гадна гэнэтийн аюултай үзэгдлийн нэг болох үер буух зэргээр мал аж ахуй, зам тээвэрт, газар нутгийн хэлбэрт бэрхшээл учруулдаг. Иймд янз бүрийн хэмжээтэй хур тунадастай өдрийн тоо, хоногийн хамгийн их хур тунадасны хэмжээг мэдэх нь чухал юм. Монгол оронд хур тунадас циклоны нөлөөгөөр хур тунадас голдуу зуны улиралд ордог. Хотын нутаг дэвсгэрт жилд дунджаар 40-70 хоног нь бороотой, 25-30 хоног нь цастай байдаг. Улаанбаатар хотын хур тунадасны нийт хэмжээ нь 2000-2010 оны хооронд 161.3 мм-288 мм хүрч нэмэгдсэн. Ерөнхийдөө хур тунадасны 95% нь хаврын эхнээс намрын сүүл хүртэл ордог бөгөөд үүний 70% нь зуны саруудад ордог.

Салхины горим

Газрын гадарга орчмын салхины горим нь тухайн орон нутгийн уул зүйн онцлог, агаар мандлын ерөнхий орчил урсгалаас хамаардаг. Салхины хурд өвлийн улиралд багасдаг нь монголын баруун хойд нутагт төвтэй эсрэг циклон тогтдогтой холбоотой. 3-6 дугаар саруудад салхи ихтэй байдгаас шалтгаалан энэ хугацаанд чийгшлийн дутагдал их байдаг. Улаанбаатар хотын салхины зонхилох чиглэл нь баруун хойд зүг юм. Сарын дундаж салхины хурд нь 1.6 м/сек-ээс (1 ба 12 дугаар сард) 4.4 м/сек (5,6 дугаар сард) хүрдэг.

Хавар, намар манай оронд дунд өргөргийн өндрийн фронтын бүс дамнаж байрлах тул фронтын гаралтай циклоны эрчимжил нэмэгдэж цаг агаар тогтворгүй болдог. Улаанбаатар орчмын салхины үнэмлэхүй их хурдын сүүлийн 5 жилийн буюу 2017-2021 оны салхины мэдээнээс харахад дээрх дурдсантай адилаар 3-6 саруудад салхи ихтэй, салхины хурд харьцангуй бусад саруудтай харьцуулахад их байна.

Нарны цацраг:

Улаанбаатар хотод жилийн 250-аас дээш хоног нартай байдаг. Жилийн дундаж хур тунадас 361 мм, ууршилт 325 мм буюу Улаанбаатар хот нь маш хуурай уур амьсгалтай. Дундаж чийгшил 0.36%. Олон жилийн дунджаас үзэхэд жилд 2816 цаг нар гийгүүлж, 12 дугаар сард 5.5-5.6 цаг өдөрт гийгүүлж, 5 дугаар сард 9.5-10 цаг нар гийгүүлдэг байна. Нийт нарны цацрагийн 40-42% нь сарнисан цацраг ба 535.3 - 599.4кВ ц/м² байдаг. Жилийн дундаж нарны цацраг 1276.7 - 1379.8 кВ ц/м².

Агаарын чийгшил:

Агаарын харьцангуй чийгшил 65 % хүрдэг ч хавар 45-55% хамгийн бага үедээ 30% үүнээс цөөнгүй

доошилж хуурайшдаг. Өвлийн саруудад үндсэн их хэмжээ 75-77% хүрч, хур борооны улиралд 2 дахь ихсэлт 68% болж, хоногт үүрээр хамгийн их чийгшиж, зуны саруудад өглөөгүүр агаар чийглэг, тохиромжтой байдаг.

Улаанбаатар хотын агаарын чанар:

Улаанбаатар хотын агаарын бохирдол нь хотын байршил, байгаль, агаар мандлын орчил урсгалын онцлог зэргээс хамаарах байгаль-нийгэм-эдийн засгийн нэгдмэл үйл явцын бүтээгдэхүүн юм. Нийслэлд агаарын бохирдлын түвшин нь бохирдлын эх үүсвэрийн байршил тэдгээрийн хүчин чадал, хаягдлын найрлага ба бүтэц, газарзүйн болон цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан хотын дүүргүүдэд харилцан адилгүй явц, тархалттай байдаг. Улаанбаатарын оршин суугчдын тэн хагас нь амьдардаг хотын захаарх эргэн тойрны уулсын энгэр дагаж байрласан гэр хорооллын утаа униар нь орчныхоо агаарыг ихээхэн бохирдуулаад зогсохгүй голын хөндий дагаж харьцангуй нам дор газар байрласан хотын төв хэсгийн агаарыг бохирдуулах нэг эх үүсвэр нь болдог.

Хүснэгт 2. Бохирдуулагч бодисын хэмжээ

№	Бохирдуулагч бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	7 хоногийн дундаж агууламж, мкг/м ³	
		24 цаг	2025 он	2026 он
		Хүлээх агууламж, мкг/м ³		
1	PM10 тоосонцор	100	185	162
2	Хүхэрлэг хий, SO ₂	50	98	84
3	PM2.5 тоосонцор	50	110	95
4	Азотын давхар исэл, NO ₂	40	55	48
5	Нүүрсгөрөгчийн дутуу исэл, CO	4000	2800	2450
6	Озон, O ₃	100	45	52

Ажлын байрны дуу шуугиан:

ДЭМБ-ын гаргасан лавлахад шуугианы түвшин суурьшлын орчинд 16 цагийн хугацаанд 50-55дБА, үйлдвэр, олон нийтийн үйлчилгээний газар, автозамын дагуу 24 цагийн турш 70дБА байхад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн байна. Эрүүл ахуйн үүднээс, хүн нэг өдөрт тасралтгүйгээр байж болох шуугианы зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоон мөрддөг бөгөөд энэ хэмжээ дэлхийн олон улсад бараг адил юм.

Хүснэгт 3. Дуу шуугианы төвшин, эрүүл ахуйн шаардлага

№	Шуугианы төвшин, дБА	Ангилал (Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдал)	Тайлбар
1	80-130	Маш таагүй нөхцөл	Эрүүл мэндэд аюултай
2	60-80	Харьцангуй тааламжгүй нөхцөл	Хэрвээ 60 дБА хүрвэл почролд, 70 дБА хүрэхийг хориглох 80 дБА хүрвэл аюулын байдалд хүрнэ
3	40-60	Харьцангуй тааламжтай нөхцөл	Байнгын хэвийн төвшин
4	20-40	Маш тааламжтай нөхцөл	20 дБА дотор маш тааламжтай нөхцөл


Монгол улсын одоогийн мөрдөж байгаа стандарт (MNS5003:2000)-д

- Гэр орон дотор 40дБА-ээс бага
- Гудамжинд 60дБА-ээс бага
- Үйлдвэрийн районд 80дБА-ээс бага хэмээн тогтоосон болно.

2.4. Газаргын ус

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрээр Сэлбэ, Туул гол дайрч өнгөрөн урсдаг байна.

Харин төслийн талбайн төв цэгээс 868 м-ийн зайд Туул гол, 576 м зайд Сэлбэ гол урсаж байна. Тус төсөл нь гадаргын усанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.




Зураг 15. Төслийн талбай орчмын гадаргын усан сүлжээ

2.5. Газрын доорх ус

Гидрогеологийн муж: Улирлын дунд тэжээлтэй муж Монголын төв хэсгийн дэд муж


Улаанбаатар хот орчмын гидрогеологийн ерөнхий нөхцөл: Улаанбаатарын газрын доорх усны ай сав,уулс хоорондын артезийн ай сав бөгөөд Хойд Туулын, Урд Туулын гэсэн 2 томоохон региональ хагарал байдгийг геологичид зураглан тогтоосон байдаг. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорх усны тэжээлийн бүс. Улаанбаатарын хотгор нь хуримтлал, зөөгдөл, хөлийн бүс болдог. Улаанбаатарын уулс хоорондын артезийн ай сав хэмжээнд палеозой, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдасны устай бүрдлүүд, устай тектоникийн ан цавын бүс тус тус тархсан байна.



Зураг 16. Газрын доорх усны нөөцийн тархалт

2.4 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрсний ангиллаар тал газар, хөндий хотгорын хөрсний ангилалд хамаарна. Харин төрлийн хувьд ердийн хар хүрэн ба сайргархаг хар хүрэн хөрсний ангилалд хамаарна.



Зураг 17. Төслийн талбайд тархсан хөрс

Төслийн талбай нь барилгажсан, талбайн хөрсөнд цементэн хатуу хучилт хийгдсэн, талбайн унаган төрх алдагдсан, талбайн ногоон байгууламжид асгамал хөрс тархсан байна.



2.6 Ургамлан бүрхэвч

Улаанбаатар хот нь ургамал газар зүйн мужаар Евроазийн шилмүүст ойн мужийн

Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрогт хамаарна. Улаанбаатар хот нь уулын ойт хээр, уулын тайга, уулын цөлийн хээр, хээрийн ба хуурай хээр, цөл, цөлийн хээр, өндөр уулын ургамалжилтын хэв шинжид хамаарна.

Монгол орны ургамал газарзүйн тойрог

(Д.Өлзийхутаг, 1989)



Зураг 18. Төслийн талбайн ургамалжилт

Төслийн талбай нь ургамлын бүсийн ангиллаар бэлчээр биш ангилалд багтах ургамлын хэв шинж зонхилно. Бүлгийн хувьд бэлчээр биш бүлэгт багтах ургамлын хэв шинж зонхилно. Харин төрлийн хувьд хотын ургамлын хэв шинж зонхилно.

Төслийн талбай нь барилгажсан, талбайн хөрсөнд хатуу хучилт хийгдсэн байх бөгөөд нийт талбайн 5 орчим хувьд ногоон байгууламж байх бөгөөд тогтмол усалгаа арчилгаа хийгддэг.

2.7. Амьтны аймаг

Төслийн талбайн орчимд ажиглалтын явцад ямар нэгэн амьтны бүлгэмдэл илрээгүй. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.




Зураг 19. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлал

2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайд улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг үгүй болно. Хамгийн ойролцоо орших Улсын ТХГН нь Богдхан уул ДЦГ бөгөөд төслийн талбай хамгаалалтын бүсэд хамаарахгүй байна.

Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.2-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.



Зураг 20. Улсын тусгай хамгаалалттай газар

2.9 Нийгэм эдийн засаг

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар “Ажилчны район” нэртэйгээр байгуулагдсан нийслэлийн ууган дөрвөн дүүргийн нэг юм.

Хан-Уул дүүрэг нь 273,398 мянга хүн амтай, 78,000 мянган өрхтэй, 25,000 аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоотой, 42,867 толгой малтай, 482,860 тахиа, 3,610 гахай бүхий эрчимжсэн аж ахуйтай, хүлэмжийн аж ахуй, агро парк бүхий газар тариалан хөгжсөн бүс нутаг юм. Дүүрэг нь 48500 га нутаг дэвсгэртэй, үүнээс 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67,6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11,3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг.

Хүн ам: Хүн амын жилийн өсөлтийн хурдыг сүүлийн жилүүдийн үзүүлэлтээр авч үзвэл: 2024-2025 онуудад 1,27 хувиар өссөн байна.


Аж үйлдвэр: Хан-Уул дүүргийн аж үйлдвэрийн газрууд нь **2024 оны** гүйцэтгэлээр нийт **2.4 их наяд** төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, **2.8 их наяд** төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт **12.6 хувиар**, борлуулалт **18.2 хувиар** тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хан-Уул дүүргийн аж үйлдвэр, уул уурхай, эрчим хүч, хөнгөн болон хүнсний үйлдвэрүүд (таны ажилладаг салбар ороод) нь Монгол Улсын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн **6.4 хувь**, нийт борлуулалтын **6.7 хувь**, Нийслэлийн нийт үйлдвэрлэлтийн **11.2 хувь**, нийт борлуулалтын **11.5 хувийг** тус тус дангаараа бүрдүүлж байна. Энэ нь тус дүүрэг Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн гол зангилаа хэвээр байгааг илтгэж байгаа юм.

Дүүргийн төсөв: Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) **2025 оны эхний 5 сарын** байдлаар **186.4 тэрбум** төгрөг болж, төсвийн орлогын бүрдүүлэлт төлөвлөсөн хэмжээнээс **24.1 тэрбум** төгрөгөөр (14.8%) давж биелсэн бөгөөд орлогын бүрдүүлэлт 2024 оноос **22.4 хувиар** өссөн байна.

Төсвийн нийт орлогын бүтцийг авч үзвэл:

- **48.2 хувийг** татварын орлого (хүн амын орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, бусад хураамж),
- **4.5 хувийг** татварын бус орлого (төрийн үйлчилгээний төлбөр, торгууль),
- **18.3 хувийг** тусламжийн орлого,
- **29.0 хувийг** улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг тус тус эзэлж байна.



Зураг 21. Төсвийн орлого, зарлага, 2020-2025 онд, тэрбум төг

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ, ЗӨВЛӨМЖ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилсан байдлаар байгалийн бүрэлдэхүүн хэсэг болох ус, хөрс, агаар, ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлыг тодорхойлов.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөллийг тодорхойлох, тоо хэмжээг тодорхойлохдоо БОНХЯ-ны сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тушаалаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалд тусгагдсан арга, аргачлалыг ашиглав.

3.1. Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн

Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан байгалийн параметруудийн нийт 6 нөлөөллийг оноот үнэлгээний аргачлалаар үнэлэхэд төслийн үйл ажиллагаанаас дуу чимээ тодорхой орчинд, богино хугацаанд үүсч ажиллагсадад нөлөөлж байна. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанар, дуу шуугиан, хог хаягдал, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамалд үзүүлэх нөлөө байхгүй.

Хүснэгт 4. Оноот үнэлгээний нэгдсэн дүн

Байгалийн хүчин зүйлс	Их	Дунд	Бага буюу нөлөөгүй
Агаарын чанар	-		1
Гадаргын ус			1
Газрын доорх ус	-	-	1
Газрын гадарга, хөрс	-	-	1
Ургамал	-	-	1
Дүн	-	-	6 (100%)

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Төслийн үйл ажиллагааны үед тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хорт хий болон түүний явалтаас үүсэх тоосжилт агаарт дэгдэх.

Хүснэгт 5. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөллийн оноот үнэлгээ

Хүчин зүйл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
	I	A1	A2	A3	B1	B2	C1	Σ		
Агаарын чанар	-1	1	1	2	1	2	1	-9	Бага	Үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгсэлээс ялгарах хорт хий агаарт дэгдэх.

Усны чанарт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Төслийн талбайд уст цэг байхгүй. Төслийн унд ахуй болон хэрэглээний усыг төвийн шугамаас авч хэрэглэнэ.

Хүснэгт 6. Гадаргын болон газрын доорх усны чанарт үзүүлж болзошгүй нөлөөллийн оноот үнэлгээ

Хүчин зүйл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
	I	A1	A2	A3	B1	B2	C1	Σ		
Гадаргын ус	0	1	1	1	1	1	1	0	Нөлөөгүй	Гадаргын усанд үзүүлэх нөлөө бага.
Газрын доорх ус	-1	1	1	1	1	1	1	-6	Бага	Газрын доорх усанд үзүүлэх нөлөө бага.

Хөрсөнд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Тээврийн хэрэгсэлээс шатах тослох материал асгарч тухайн хэсгийн хөрсөн бүрхэвч болон агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Хүснэгт 7. Хөрсөнд үзүүлж болзошгүй нөлөөллийн оноот үнэлгээ

Хүчин зүйл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
	I	A1	A2	A3	B1	B2	C1	Σ		
Хөрс	-1	1	1	1	1	1	1	-6	Нөлөөгүй	Ажилчид болон үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгсэлээс шатах тослох материал асгарах.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Төслийн гаднах тохижилтыг сайн хийж гүйцэтгэсэн, сул талбайд ногоон байгууламж цогцоор нь

шийдэн зүлэгжүүлэн, мод тарьсан.

Хүснэгт 8. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн оноот үнэлгээ

Хүчин зүйл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн зэрэг	Тайлбар
	I	A1	A2	A3	B1	B2	C1	Σ		
Ургамал	-1	1	1	2	1	1	1	-6	Нөлөөгүй	Хүн болон механик хүчин зүйлийн нөлөөгөөр ургамлан нөмрөгт дарамт учруулах.

Нөлөөллийн төрөл		Нөлөөллийн эх үүсвэр /үйл ажиллагаа/	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
Агаар			
1.1	Агаар бохирдох, агаарын чанар муудах	Химийн бодисын ууршилт Санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис алдагдах Химийн бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн утаа	Ажиллагсдын эрүүл мэнд болоод ойр орчмын хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. Байнгын бус, түр зуурын шинж чанартай.
Усан орчин			
2.1	Гүний ус бохирдох Гүний усны чанар өөрчлөгдөх	Химийн бодис алдагдах Тээвэрлэлтийн явцад шатах тослох материалын алдагдал, хаягдал	Химийн бодис хөрсөнд нэвчин улмаар гүний усыг бохирдуулж, гүний усны чанарт нөлөөлж болзошгүй.
2.2	Ус сувгийн нэгдсэн системд юүлэгдэх ус уравлын орчны хувьд өндөр байх	Хэвлэлийн үйлдвэр нь шингэн хаягдал хаяхдаа урьдчилан зориулалтын шүүлтүүрээр шүүдэггүй. Шингэн хаягдлаа төвлөрсөн бохирын шугамд юүлдэг.	Тус үйлдвэрийн шингэн хаягдал нь хүчтэй хортой бодис агуулагдаагүй ч гэсэн олон төрлийн амоны давснууд агуулж байгаа нь хүчтэй хүчил, исэлдүүлэгч, ангижруулагчтай урвалд орж хортой хий ялгаруулах болзошгүй
Хөрс			
3.1	Хөрсний бохирдол	Химийн бодисын алдагдал Ахуйн хог хаягдал	Химийн бодис, түүний сав баглаа боодол, болон бусад хог хаягдлыг зүй бусаар зайлуулсны улмаас хөрс бохирдох, улмаар хөрсөөр нэвчин гүний ус бохирдож болзошгүй.
Ургамлан нөмрөг			
4.1	Ургамлан нөмрөгийн талхлагдал	Хөрсний бохирдол, талхлагдал Хүний болон техникийн үйл ажиллагаа, объектуудын ойр орчим	Машин техникийн хөдөлгөөн, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдана.
Хүний эрүүл мэнд			
5.1	Химийн бодис, үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэндэд эрсдэл бий болох. Дэгдэмхий Ууршимтгай, органик бодисын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан ялгарал	Химийн бодисын тээвэрлэлт, зүй бус хадгалалт, ашиглалт. Ажлын байрны дотоод орчны агаарын бохирдол, Үйлдвэрийн аваар осол, аюулгүй байдал алдагдах, хангаагүй байх, ажилчидыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангахгүй байх	Химийн бодисын тээвэрлэлт, зүй бус хадгалалт, ашиглалт зэргийн улмаас ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх Үйлдвэрийн аваар осол, аюулгүй байдлыг хангаагүйн улмаас хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах
5.2	Ажлын байран дээрх дуу шуугиан	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжөөс гарах дуу шуугиан	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжөөс гарах дуу шуугиан нь ажилчдын тав тухыг алдагдууах, удаан хугацаагаар ажиллахад эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, дуу шуугианаас сэргийлэх хувийн хамгаалах хэрэгсэл хэрэгслийн дугмаг байдал болон зүй бус хэрэглээнээс эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Энэ бүлэгт төслөөс нийгэм, эдийн засагт болон ажиллагсдад учирч болзошгүй нөлөөллийг үйл ажиллагааны одоогийн ба ирээдүйн хандлагыг тооцсоны үндсэн дээр тодорхойлсон бөгөөд матрицын үнэлгээний аргыг ашигласан болно.

Матрицын үнэлгээний аргачлал

Нийгэм, эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээг матрицын аргаар тодорхойлсоныг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9. Нийгэм, эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ

Нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн		Болзошгүй нөлөөлөл	
		Эерэг нөлөөлөл	Сөрөг нөлөөлөл
1.	Татвар төлөлт	(+)	
Дүн		1 (100%)	0

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийг урьдчилан тооцоход 100 % эерэг нөлөөтэй байна.

3.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх.
- Машин механизм, тээврийн хэрэгслээс бензин, тос тосолгооны материалын асгаралт алдагдал үүсэж усан орчинг бохирдуулахаас сэргийлэх.
- Шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, тостой даавуу сэлбэг хэрэгсэл (аккумулятор, хаягдал олгой, дугуй гэх мэт)-ийн хаягдлыг ил задгай хаяхгүй байх.

3.3. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ногоон байгууламж буюу бут сөөг, зүлэгжүүлэлтийг арчлах, тордох, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

3.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ажилчдыг засмал зам талбайгаар явахыг сануулсан тэмдэглэгээ байршуулах.
- Шатах тослох материал асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

3.5. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

- Агуулахын нөхцөлд /температур, чийг, агаарын солилцоо, нарны тусгал г.м/ байнгын хяналт тавьж, дүүргийн онцгой байдлын алба, мэргэжлийн хяналтын газартай харилцан хамтран ажиллах хэрэгтэй.
- Ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах, ажлын талбарыг тохижуулах
- Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг сард 1-2 удаа тогтмол нэгдсэн хогийн цэгт эрх бүхий байгууллагаар зөөвөрлүүлэх.
- Тээврийн хэрэгслээс их хэмжээний хар утаа ялгарч буй ажиглагдсан тохиолдолд тухайн төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны журмын дагуу унтрааж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх.

3.6. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний зөвлөмж

- Төслийн талбай түүний ойр орчмын хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн хог хаягдлаас мал амьтан хордож болзошгүй учир үүнээс сэргийлж хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах хэрэгтэй.
- Ажилчдын орон байр, агуулахад элдэв мэрэгчид, шувуу, шавж элбэгших явдлыг хянах, хүн малын халдварт өвчин гарах, тархахаас сэргийлэх.

3.7. Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Төслийн бүх ажилчдад ажил үүргийн хуваарьтай нь уялдуулан аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтад хамруулж байх.
- Ажилчдад болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгөх.
- Анхны тусламжийн хайрцгийг ажлын талбайд бэлэн байлгах.
- Төслийн ажилчид болон дүүргийн иргэдээс гомдол санал ирсэн тохиолдолд хүлээн авч цаг алдалгүй зохих шатанд нь шийдвэрлэж хариу өгч байх.
- Цаашид ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэршүүлж эргүүлэн ашиглах тал дээр анхаарч ажиллах.

3.8. Уширлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.
- Аюултай, Энгийн хог хаягдал тээвэрлэх гэрээний хугацаа дууссан тохиолдолд тухай бүрд сунгаж ажиллах.
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга) болоход гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, ажиллагсдыг сургалтад хамруулж дадлагажуулах, эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг талбайд байрлуулах.
- Хан-Уул дүүргийн захиргаатай хамтран ажиллах, жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайланг хүргүүлж санал авах

- Улс, орон нутгийн төсөвт төлөх татвар хураамжийг цаг тухайд нь төлөх.

3.9. Галын аюулгүй байдлыг хангах талаар:

- Ажилчдын барилга нь галын дохиоллын системтэй байна.
- Үйлдвэрийн байранд нийт 132 гал унтраагуур, 5 галын сарай байршсан, мөн пресс машины хэсэгт автомат тунгус байршуулсан.

3.10 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж

Нийтлэг шаардлага

- Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлог тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж, тэдгээрийг хэрэглэх үүрэгтэй.
- Ажилтнууд өөрсдийн ажлын байранд холбогдох хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааврыг удирдлага болгоно.
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны нөхцөлд байнга хяналт тавьж, осол аюул гарсан тохиолдолд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, холбогдох сургалтыг явуулах.
- Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл болон тохижилтыг дээд зэргээр ханган, байнгын хяналт тавин ажиллах.
- Агуулахад хадгалах нэр төрлийн химийн бодисуудын осол аюулын тохиолдолд учруулж болзошгүй хор нөлөө, хордлогын шинж, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулыг арилгах, саармагжуулах арга, ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламжтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Ажиллагсдыг ажилд ороход нь эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулахын зэрэгцээ эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.
- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажилчдын хоол хүнсний аюулгүй байдалд анхаарч ажиллах.
- Хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг чанд даган мөрдөж ажиллах.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан гол сөрөг нөлөө болон болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад чиглэгдсэн байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж төслөөс үүдэн гарах байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, хамгаалахад гол зорилго нь оршино.

4.1. БОМТ-ны нийт зардал

№	Зардлын ангилал	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	1,000,000
2	Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал	1,000,000
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний зардал	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах зардал	-
5	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн зардал	2,000,000
6	Хөг хаягдлын менежментийн зардал	1,500,000
7	ОХПХ-ын зардал	1,300,000
8	Удирдлага зохион байгуулалт	1,000,000
9	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь	-
Нийт зардал		7,800,000

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Дүснэгт 10. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл	Усыг үр ашигтай хэрэглэх талсаар ухуулаа, сурталчилгааг ажигчдад хийх, мэдээллийн хуудсыг хяналтын зарын самбарг, шийгийн бие засах газар байрдуулж шинэчилж байх	Нийт ажигчдад	Дотоод зардал				2026 он	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам
	Шингэн хаягдлын pH – г нь 6-9 болгох, усаар шингэлэн хэсэгчлэн урсгаж хаях аргыг хэрэглэх	Хэвтэх үйлдвэрийн орчинд	Дотоод зардал				2026 он	
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	Ашиглагдаж буй машин техникийг үзлэгт хамруулах, агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Хэвтэх үйлдвэрийн орчинд	Дотоод зардал				2026 он	MNS ISO4227-2002 Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хууцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага MNS 4990-2000 ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5014:2009 Дизель хөдөлгүүргүй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
	Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах	Хэвтэх үйлдвэрийн орчинд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө				2026 он	
	Үйлдвэрийн нийт агааржуулалтын системийг сайжруулах, агааржуулалтын системийн аюулгүй байдлыг тогтмол хянах	Хэвтэх үйлдвэрийн орчинд	-	1,000,000	1	1,000,000	Тухайн бүрд	
Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Ажигчдыг хувийн хамгаалах хувцас хэрэгслээр хангах, ялангуяа дотоод орчинд ажиллаж байгаа ажигчдад хамгаалах маек зүүлгэж байх	Хэвтэх үйлдвэрийн орчинд	Үйл ажиллагааны зардал оруулах				2026 он	-MNS 6768:2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шугуйны өртөлтийн хэмжилт, зөвшөөрөгдөх дээд хэмжээ, ажиглгны сонголт хамгаалахад тавих ерөнхий шаардлага
Нийт			1,000,000					

ЗУРГАА. ОСОЛ. ЭРСЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ю БИ ПИ ХХК-ний дотоод аюулгүй ажиллагаа болон гэнтийн ослын үеийн эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон ХАБЭА арга хэмжээгээр хэрэгжүүлнэ.

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн орлог /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, техник саатах, технологийн шугам сүлжээний гэмтэл, галын аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах.	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжинд	Дотоод зардал	Тухай бүрд	Тухай бүрд	Гамшгаас хамгаалах тухай хууль.
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулна.	Үйлдвэрийн ажилчдад	1.000.000	1.000.000		
Нийт /мян.төг/		1.000.000				

ДОЛОО. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө байхгүй

НАЙМ. ТҮҮХ. СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн харяалагдах Хан-Уул дүүрэг нь Нийслэл хотын хамгийн том дүүрэг юм. Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.2-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авна.

Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

ЕС. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

МУЗГТ-н 350 дугаар 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн Хөрс хамгаалах, цөлийгөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Салхины хаалт хамгаалагчид хашаалж ургадаг мод тарих боломж, туршилтыг судалж нэвтрүүлэх хэрэгтэй. Оффис, ажлын байрны орчимд цэцгийн мандал байгуулах. Орчны тохижилтын ерөнхий төлөвлөгөө болон байгаль хамгаалах төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөд заасан хөгөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

Хүснэгт 11. 2026 оны Но.оон байгуулалжийн төлөвлөгөө

Орчны тохивилт, нөлөрлөгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
"Гэрбум мод" хүрээнд төслийн талбайд мод, бут тарималжуулах	Шилмүүст мод	Ногоон байгууламж	ш	100	20,000	2,000,000	2026 он	МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр "Гэрбум мод" Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Нийт						2,000,000		

АРАВ. ХОГ. ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид 2026 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 12. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Ари.гах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, дахин ашиглах боломжтой зүйлс (цаас, шил, хуванцар сав, ашигласан тос, хаягдал дүгуй г.м)-ийг шаардлагагүй газруудад нийлүүлэх;	Хог хаягдлын ангилан ялгах цэгийн менежментийг сайжруулна		ш	1,000,000	1	1,000,000	2025 он	Хог хаягдлын тухай хууль; Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; MNS 5344 : 2011
	Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Үйлдвэр, Оффис орчим	ш	500,000	1	500,000	2025 он	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; Застийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам.
	Химийн болисын хаягдал, сав баглаа боодлыг БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайд, ОБЕГ-ын дарга нарын хамтарсан тулаал "Химийн хорт болон аюултай бодис устгах" журмын дагуу устгах		кг	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он		
	Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээг ААН (тохижилт үйлчилгээний ОНГААГУГ)-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Үйлдвэр орчим	кг	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он		
Нийт						1,500,000		

АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь тус төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

Хүснэгт 13. Төслийн орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал	Нийт зардал	Төрөл	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанарын хяналт							
Дотоод орчны дуу шуугианы хэмжээ	Уйлдвэр орчим	Улирал	4	60.000	240.000	NO ₂ , SO ₂ , H ₂ S, CO, VOCs-BTEX) CO ₂	MNS 4585:2016 Монгол улсын агаарын чанарын стандарт Агаарт байх бохирдуулах бодисын хүлээх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885:2008/
Дэгдэмхий органик нэгдэл	Өнгөг хэвтэлийн өрөө, боолтын өрөө	Жилд	1	300.000	300.000	- Бензол - Трихлорэтилен - Толуол - П-ксилол - М-ксилол - Стирол - 1,4-дихлорбензол - 1,2-дихлорбензол	MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага; MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ; MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга; MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга; MNS0012-1-015:1987. Чимгээ шуугиан-Ажлын байрны чимгээ шуугианыг хэмжих арга; MNS0017.2.5.12:1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь хүүхэртэй хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS0017.2.5.11-1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS5365:2004. Агаарын чанарын ерөнхий асуудал.
Агаар дахь формальдегид болон бусад органик бичил нэгдэл	Өнгөг хэвтэлийн өрөө, боолтын өрөө	Жилд	1	500.000	500.000	- Азотын давхар исл, NO ₂ - Формальдегид, CH ₂ O	
Усан орчны хяналт							
Г/ДУ геохимийн судалгаа: Макро, микро элемент	Төвийн шугамнаас	Улирал бүр	4	65.000	260.000	HCO ₃ , SO ₄ , CL, Na, K, Mg, Ca бусад	MNS 0900:2018
Нийт				1.300.000			

АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүснэгт 14. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		Сар	Сар	Сар		
Тухайн жилийн БОМТ төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу жил бүр боловруулан БОУАОЯ-аар батлуулах;	Дотоод зардал	2026 он	2025 он	2026 он	Гүйцэтгэх захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль орчны аудитын хэрэгжилтийг хангаж ажиллах	1.000.000	2026 он			Гүйцэтгэх захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хордлого тайлах хүн, бэлдмэлээр хашгаж байх	Дотоод зардал	2026 он			Гүйцэтгэх захирал	
Нийт	1.000.000					

АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧЛАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэвлэлийн үйлдвэр нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОУАӨЯ-д тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил хүргүүлнэ.

Дүснэгт 15. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагснах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал	Хариуцсан албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОМТ-ыг таниулах, мэдэрэх, таниулах дүүргийн ИНХ	Цаасап хэлбэрээр, Танилцуулга	Төлөвлөгөөг Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 дугаар сард	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал, ХАБЭА-н менежер	-
Нийслэлийн Байгаль орчны газар	Тайлан	БОМТ-ний биелэлтийн тайлан	11-р сарын 1 ний дотор	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал, ХАБЭА-н менежер	-
Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага	Тайлангаар танилцуулж бичгээр санал авна	Дараа жилийн БОМТ-г батлуулах	12-р сарын 30 ны дотор	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал, ХАБЭА-н менежер	-